

Г МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ ХК-д Г

Мэдээлэл хүргүүлэх тухай

“Мандал Ирээдүйн Өсөлт Хамтын ХОС” ХХК нь 2026 оны 04 дүгээр сарын 27-ны өдрийн Нэгж эрх эзэмшигчдийн ээлжит хурлаар дараах шийдвэрүүдийг гаргасан болно.

1. Сангуудын Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга Н.Монсорыг бүрэн эрхийг хугацаанаас өмнө дуусгавар болгосон;
2. Сангуудын Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнээр Г.Мөнх-Ирээдүйг томилсон.

Түүнчлэн, Компанийн тухай хууль болон сангийн дүрэмд Төлөөлөн удирдах зөвлөлийн даргыг төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн дотроос нийт гишүүний олонхийн саналаар сонгох үндэслэлээр 2026 оны 06 дугаар сарын 09-ний өдөр хуралдаж, Ж.Дэлгэрсайханыг Төлөөлөн удирдах зөвлөлийн даргаар томилох шийдвэрийг гаргасан болно.

Иймд дээрх өөрчлөлт, томилгооны талаарх мэдээллийг хүргүүлж байна.

Хавсралт: Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэр-1 хуудас

ГҮЙЦЭТГЭХ УДИРДЛАГА



Э.МИШЭЭЛ

МАНДАЛ ИРЭЭДҮЙН ӨСӨЛТ

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН САН

2026 оны 06 сарын 09 өдөр

№ 26/008

Улаанбаатар хот

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дарга томилох тухай

Компанийн тухай хуулийн 78 дугаар зүйлийн 78.1 дэх хэсэг, Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулийн 9 дүгээр 9.4 дэх хэсэг, “Мандал Ирээдүйн Өсөлт хамтын ХОС” ХХК-ийн дүрмийн 10 дугаар зүйлийн 10.6 дахь хэсэг, Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2026 оны 06 дугаар сарын 09-ны өдрийн ээлжит хурлын цахим санал хураалтын дүнг тус тус үндэслэн ТОГТООХ НЬ:

1. “Мандал Ирээдүйн өсөлт хамтын ХОС” ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн даргаар Ж.Дэлгэрсайханыг сонгосугай.
2. Сангийн Төлөөлөн Удирдах зөвлөлийн үйл ажиллагааг зохион байгуулах, хурлыг даргалах, хяналт тавьж ажиллах, Компанийн тухай хууль болон холбогдох дүрэм, журам, сангийн дүрэмд заасан эрх үүргийг хэрэгжүүлэхийг үүрэг болгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА

Ж.ДЭЛГЭРСАЙХАН

